



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Иххэт сумын ерөнхий боловсролын сургуулийн
2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/98/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn

Дорноговь аймаг
Сайншанд сум
2023 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991

Цахим хаяг: oyuntuuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд судасан,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Цэхим хуудас: dornogovii.audit.gov.mn

2022.02.24 № А-6/158

тантай _____-ны № _____-т

**ИХХЭТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ С.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Иххэт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйцээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн Иххэт сумын ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг өмнөх онтой харьцуулахад Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтаар төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 97.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

01000450

Илрүүлэлтээр малын тоо толгойн албан татварын тайлан гаргаагүй, татвар төлөөгүй байна. Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн "5.1.Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна", "7.3.Албан татвар төлөгч албан татварын тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгэж, тухайн татварын жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяа татварын албанд хүргүүлнэ" гэсэн хуулийн заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Анхан шатны баримтын тулгалтаар 13 харилцагчдаас 86.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д "анхан шатны баримт" гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог, 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтууд, НӨАТ-ын тухай хуулийн 4.1.14-т "төлбөрийн баримт" гэж тухайн төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох он, сар, өдөр, дахин давтагдашгүй төлбөрийн дугаар бүхий нэгдсэн системээр баталгаажсан, албан татвар суутган төлөгч буюу худалдаа эрхлэгчийг таних тэмдэг бүхий нэр, хаяг, татвар төлөгчийн дугаар, худалдаа хийгдсэн бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, төлбөр тооцооны болон татварын дүн зэрэг мэдээллийг агуулсан зориулалтын тоног төхөөрөмжөөс гаргасан цаасан болон цахим баримтыг", 17.3.2-т "бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,131.2 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 999.3 сая төгрөгийн 37 гүйлгээг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13.6 сая төгрөгийн орлогын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 19.6 сая төгрөгийн 7 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:" 6.4.5 "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8 "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр"; заалтуудтай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж гарын үсгээр баталгаажуулаагүй байна. Энэ нь УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан "аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах", "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

2022 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 18 зорилт, 38 арга хэмжээний хэрэгжилт 93 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 90.5 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т. ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	109,265,121.61	220,702,899.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	97,817,915.42
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	97,817,915.42
3121	Төгрөг	-	97,817,915.42
31211	Төрийн сангийн харилцах	-	97,817,915.42
33	АВЛАГА	5,354,606.72	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,028,656.72	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	3,325,950.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	103,910,514.89	122,884,984.41
351	Түүхий эд материал	159,340.00	289,718.00
35130	Эм боох материал	159,340.00	289,718.00
354	Хангамжийн материал	100,346,174.89	118,080,266.41
35410	Бичиг хэргийн материал	10,650,121.20	18,300,094.72
35420	Аж ахуйн материал	71,608,073.69	80,394,141.69
35440	Тулш, шатах тослох материал	230.00	230.00
35460	Хүнсний материал	2,621,950.00	3,920,000.00
35470	Бусад хангамжийн материал	15,465,800.00	15,465,800.00
35600	Мал амьтад	3,405,000.00	4,515,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,043,335,532.34	990,823,849.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,043,335,532.34	990,823,849.59
392	Биет хөрөнгө	1,004,802,115.54	952,722,182.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	972,214,836.00	972,214,836.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(64,814,486.70)	(104,988,288.18)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	193,878,102.57	223,825,502.57
39206	Хуримтлагдсан элэгдэл	(164,583,270.28)	(189,016,019.16)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	108,237,589.82	108,237,589.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,306,753.49)	(90,565,836.00)
39214	Бусад үндсэн хөрөнгө	31,000,000.00	31,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,649,999.66)	(24,049,999.62)
39217	Ном	25,826,097.28	26,064,397.28
393	Биет бус хөрөнгө	38,533,416.80	38,101,666.88
39301	Програм хангамж	2,327,000.00	2,327,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,319,583.20)	(1,751,333.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	37,526,000.00	37,526,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,152,600,656.95	1,211,526,749.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,218,690.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,218,690.00	-
413	Өглөг	2,218,690.00	-
4136	Бусад өглөг	2,218,690.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	190.00	-
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	2,218,500.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,150,381,966.95	1,211,526,749.42
51	Засгийн газрын хувь оролцоо	1,150,381,966.95	1,211,526,749.42
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	530,079,516.49	530,079,516.49
51101	Өмч: - төрийн	530,079,516.49	530,079,516.49
512	Хуримтлагдсан үр дүн	267,844,699.72	328,989,485.19
51210	Өмнөх үеийн үр дүн	267,844,699.72	267,844,699.72
51220	Тайлант үеийн үр дүн	-	61,144,785.47
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	352,457,747.74	352,457,747.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,152,600,656.95	1,211,526,749.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	756,269,592.81	1,030,635,328.65
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	11,891,663.52
120	Нийтлэг татварын бус орлого	-	11,891,663.52
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	3,390,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,390,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	190,300.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	8,311,363.52
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	756,269,592.81	1,018,743,665.13
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	565,583,800.00	791,684,600.00

131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	791,684,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	565,583,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,950,118.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,950,118.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,735,674.81	227,059,065.13
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,735,674.81	227,059,065.13
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	844,879,112.54	965,785,543.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	844,879,112.54	965,785,543.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	834,664,049.70	965,785,543.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	463,159,766.85	537,548,862.02
210101	Үндсэн цалин	390,740,348.72	400,372,864.52
210102	Нэмэгдэл	49,966,303.95	109,478,990.50
210104	Урамшуулал	22,453,114.18	27,697,007.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,516,526.31	67,235,425.57
210201	Тэтгэврийн даатгал	43,014,027.84	46,718,252.79
210202	Тэтгэмжийн даатгал	4,389,158.05	5,428,888.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,832,383.65	4,316,230.68
210204	Ажилгүйдлийн даатгал	789,804.37	922,717.19
210205	Эрүүл мэндийн даатгал	8,491,152.40	9,849,336.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,752,174.81	182,064,195.84
210301	Гэрэл, цахилгаан	4,850,382.81	7,244,800.55
210302	Түлш, халаалт	165,633,160.00	165,633,160.00
210303	Цэвэр, бохир ус	6,268,632.00	9,186,235.29
2104	Хангамж, бараа материалын зардал	17,981,014.72	11,283,850.00
210401	Бичиг хэрэг	788,050.00	1,064,800.00
210402	Тээвэр, шатахуун	3,828,740.00	3,886,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	909,335.00	-
210404	Ном, хэвлэл	1,761,218.00	136,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,215,322.00	63,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,936,450.00	3,997,650.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3,000,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	4,541,899.72	2,135,720.00
2105	Нормативт зардал	30,030,823.00	66,217,690.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	893,250.00	435,990.00
210502	Хоол, хүнс	29,137,573.00	65,781,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,805,500.00	6,009,500.00
210604	Урсгал засвар	1,805,500.00	6,009,500.00
2107	Томилолт, зочны зардал	230,000.00	-
210702	Дотоод албан томилолт	230,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,887,078.00	3,180,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,887,078.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	3,180,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,301,166.01	92,246,019.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,989,937.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,634,500.00	1,558,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	75,666,666.01	82,697,382.75
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,215,062.84	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,279,452.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,571,952.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	707,500.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,935,610.84	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,935,610.84	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(88,609,519.73)	64,849,785.47
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	166,666.89	3,705,000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	166,666.89	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал бараа материал	-	3,705,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(166,666.89)	(3,705,000.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(88,776,186.62)	61,144,785.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	756,269,592.81	1,028,912,031.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	5,171,900.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	5,171,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	5,171,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,781,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,390,000.00

13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	756,269,592.81	1,023,740,131.13
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	565,583,800.00	791,684,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	791,684,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	565,583,800.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,950,118.00	4,996,466.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	10,950,118.00	4,996,466.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	179,735,674.81	227,059,065.13
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	179,735,674.81	227,059,065.13
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	732,967,642.81	909,098,315.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	732,967,642.81	909,098,315.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	712,264,931.97	870,168,825.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,042,224.16	535,520,205.89
210101	Үндсэн цалин	297,166,673.21	395,201,718.00
210102	Нэмэгдэл	106,651,327.21	112,333,591.89
210104	Урамшуулал	33,224,223.74	27,984,896.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,666,400.00	67,235,424.98
210201	Тэтгэврийн даатгал	44,172,100.00	46,850,351.40
210202	Тэтгэмжийн даатгал	3,873,600.00	5,314,251.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,098,800.00	4,231,720.81
210204	Ажилгүйдлийн даатгал	774,800.00	985,405.43
210205	Эрүүл мэндийн даатгал	7,747,100.00	9,853,696.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	176,752,174.81	182,064,225.84
210301	Гэрэл, цахилгаан	4,850,382.81	7,244,800.55
210302	Түлш, халаалт	165,633,160.00	165,633,160.00
210303	Цэвэр, бохир ус	6,268,632.00	9,186,265.29
2104	Хангамж, бараа материалын зардал	9,467,218.00	-
210401	Бичиг хэрэг	527,400.00	-
210402	Тээвэр, шатахуун	3,097,980.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,242,420.00	-
210404	Ном, хэвлэл	1,646,318.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,458,300.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,494,800.00	-
2105	Нормативт зардал	15,822,315.00	30,258,760.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	359,840.00	-
210502	Хоол, хүнс	13,962,775.00	30,258,760.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,499,700.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,513,500.00	7,316,700.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	530,000.00	-
210604	Урсгал засвар	2,983,500.00	7,316,700.00
2107	Томилолт, зочны зардал	230,000.00	-
210702	Дотоод албан томилолт	230,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,085,900.00	7,792,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,085,900.00	1,781,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	6,011,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,685,200.00	39,980,609.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	29,933,911.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,685,200.00	10,046,698.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,702,710.84	38,929,490.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	14,767,100.00	38,929,490.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,867,600.00	38,929,490.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	899,500.00	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,935,610.84	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,935,610.84	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	23,301,950.00	119,813,715.42
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,976,000.00	21,995,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,976,000.00	21,995,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,976,000.00	21,995,800.00
222001	Тоног төхөөрөмж	19,575,000.00	21,947,800.00
223001	Бусад хөрөнгө	401,000.00	48,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(19,976,000.00)	(21,995,800.00)
8	НИИТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	3,325,950.00	97,817,915.42
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		97,817,915.42

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	530,079,516.49	352,457,747.74	267,844,699.72	1,150,381,963.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	530,079,516.49	352,457,747.74	267,844,699.72	1,150,381,963.95
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	530,079,516.49	352,457,747.74	267,844,699.72	1,150,381,963.95
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	530,079,516.49	352,457,747.74	267,844,699.72	1,150,381,963.95
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	530,079,516.49	352,457,747.74	267,844,699.72	1,150,381,963.95
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	61,144,785.47	61,144,785.47
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	530,079,516.49	352,457,747.74	328,989,485.19	1,211,526,749.42

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,029,020,000.00	931,094,115.71	97,925,884.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,029,020,000.00	909,098,315.71	119,921,684.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	988,570,200.00	870,168,825.71	118,401,374.29
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	616,197,000.00	535,520,205.89	80,676,794.11
210101	Үндсэн цалин	465,655,900.00	395,201,718.00	70,454,182.00
210102	Нэмэгдэл	133,999,000.00	112,333,591.89	21,665,408.11
210104	Урамшуулал	16,542,100.00	27,984,896.00	(11,442,796.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,947,200.00	67,235,424.98	9,711,775.02
210201	Тэтгэврийн даатгал	52,324,100.00	46,850,351.40	5,473,748.60
210202	Тэтгэмжийн даатгал	6,155,800.00	5,314,251.22	841,548.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,924,500.00	4,231,720.81	692,779.19
210204	Ажилгүйдлийн даатгал	1,231,200.00	985,405.43	245,794.57
210205	Эрүүл мэндийн даатгал	12,311,600.00	9,853,696.12	2,457,903.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	182,150,700.00	182,064,225.84	86,474.16
210301	Гэрэл, цахилгаан	7,235,700.00	7,244,800.55	(9,100.55)
210302	Түлш, халаалт	165,633,200.00	165,633,160.00	40.00
210303	Цэвэр, бохир ус	9,281,800.00	9,186,265.29	95,534.71
2105	Нормативт зардал	30,384,600.00	30,258,760.00	125,840.00
210502	Хоол, хүнс	30,384,600.00	30,258,760.00	125,840.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,336,300.00	7,316,700.00	19,600.00
210604	Урсгал засвар	7,336,300.00	7,316,700.00	19,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,592,000.00	7,792,900.00	799,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,783,700.00	1,781,900.00	1,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,808,300.00	6,011,000.00	797,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,962,400.00	39,980,609.00	26,981,791.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	56,749,900.00	29,933,911.00	26,815,989.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,212,500.00	10,046,698.00	165,802.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,449,800.00	38,929,490.00	1,520,310.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,449,800.00	38,929,490.00	1,520,310.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	40,449,800.00	38,929,490.00	1,520,310.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	21,995,800.00	(21,995,800.00)
2200	Дотоод эх үүсвэрээр	-	21,995,800.00	(21,995,800.00)
222001	Тоног төхөөрөмж	-	21,947,800.00	(21,947,800.00)
223001	Бусад хөрөнгө	-	48,000.00	(48,000.00)
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,029,020,000.00	1,028,912,031.13	107,968.87
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	801,854,700.00	791,684,600.00	10,170,100.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	801,854,700.00	791,684,600.00	10,170,100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	227,165,300.00	227,059,065.13	106,234.87
132001	Орон нутгийн төсвөөс	227,165,300.00	227,059,065.13	106,234.87
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	10,168,366.00	(10,168,366.00)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,781,900.00	(1,781,900.00)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	3,390,000.00	(3,390,000.00)
120009	Нэмэлтийн дансны үлдэгдлээс санхүүжих	-	4,996,466.00	(4,996,466.00)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	97,817,915.42	(97,817,915.42)
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	40.00	40.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	22.00	22.00	-

620003	Үйлчлэх ажилтан	17.00	17.00	-
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	392.00	392.00	-
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	392.00	392.00	-
630001	Төрийн өмчит ЕБС	392.00	392.00	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	4,996,466.00
213305	Нэмэлт дансны үлдэгдэл төвлөрүүлэх шилжүүлэг		4,996,466.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,996,466.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,996,466.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		4,996,466.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22.9 сая төгрөгийн 5 алдаа¹ илэрснээс аудитын явцад 22.9 сая төгрөгийн 5 алдааг залрууллаа.

Залруулсан алдаа:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй ирснийг;
2. Дахин үнэлэгдсэн барилга байгууламжийн ашиглалтын хугацааг алдаатай тавьсан, 14.0 сая төгрөгийн элэгдэл дутуу байгуулсныг, ;
3. Цалингийн зардалд 0.3 сая төгрөгийн бараа материалын зардал тусгасныг;
4. Сурах бичгийн 1.8 сая төгрөгийн түрээсийн буцаан төлөгдөх орлогыг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэснийг;
5. Мөнгөн хөрөнгийн данс хооронд шилжүүлсэн 6.8 сая төгрөгийн ажил гүйлгээг үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэснийг;

Аудитаар нийт 5 зөрчил² илэрснээс 0.5 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

3.1 Төлбөрийн акт

Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард 41 хувиар буюу 0.5 сая төгрөгийг тооцож олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.20-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.18, 14.1.19-д зааснаас бусад төсвийн”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

3.2 Албан шаардлага

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,131.2 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 999.3 сая төгрөгийн 37 гүйлгээг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13.6 сая төгрөгийн орлогын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 19.6 сая төгрөгийн 7 шийдвэрийг огт мэдээлээгүй байна. Энэ нь төсөв, өмч, хөрөнгө, мөнгө шамшигдуулах, орлого нуун дарагдуулах, зориулалтын бус, үр ашиггүй зарцуулалт хийгдэх үр дагавартай.

Мөн Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ:” 6.4.5 “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, 6.4.8 “бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”; заалтуудтай нийцээгүй байна.

3.3 Зөвлөмж

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Илрүүлэлт: Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж шалгаагүй байна. Энэ нь өмч, хөрөнгө дутагдах, ашиггүй зарцуулагдах, бодитой мэдээллээр хангагдаж чадахгүй байх үр дагавартай.

Мөн УСНББОУС-1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.3, 20.2.6-д заасан “аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийн орлого, зарлагын баримт болон санхүүгийн тайланд хоёрдугаар гарын үсэг зурах”, “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодогч сар бүр эд хариуцагчийн тайланг хянан, тоо ширхэгийг тодорхой гаргаж, гарын үсэг болон бусад баталгаажуулалтыг ханган хариуцлагатай ажиллах.

2. Төлбөрийн цахим баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Анхан шатны баримтын тулгалтаар 13 харилцагчдаас 86.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна. Энэ нь төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах үр дагавартай.

Мөн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүйгээс гадна НББ-н тухай хуулийн 3.1.3-д “анхан шатны баримт” гэж ажил, гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлдэг гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоо; 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Хүчин төгөлдөр анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллах

3. Малын хөлийн албан татвартай холбоотой асуудал

Илрүүлэлт: Малын тоо толгойн албан татварын тайлан гаргаагүй, татвар төлөөгүй байна. Энэ нь санхүүгийн тайлан алдаатай илэрхийлэгдэх үр дагавартай.

Мөн Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн “5.1.Албан татвар төлөгчийн өмчилж буй Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа малын тоо толгойд албан татвар ногдуулна”, “7.3.Албан татвар төлөгч албан татварын тайланг батлагдсан маягтын дагуу бэлтгэж, тухайн татварын жилийн 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор харьяа татварын албанд хүргүүлнэ” гэсэн хуулийн заалтуудтай нийцэхгүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Малын тоо толгойн албан татварыг төлж тайланг гаргах

Дээрх зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайлан зөрүүтэй ирсэн	1	7,430.5	0	-	1	7,430.5	1	7,430.5	0	-		
Дахин үнэлэгдсэн барилга байгууламжийн ашиглалтын хугацааг алдаатай тавьсан, 14.0 сая төгрөгийн элэгдэл дутуу байгуулсан	1	14,039.4	0	-	1	14,039.4	1	14,039.4	0	-		
Цалингийн зардалд 0.3 сая төгрөгийн бараа материалын зардал тусгасан	1	347.0	0	-	1	347.0	1	347.0	0	-		
Сурах бичгийн 1.8 сая төгрөгийн түрээсийн буцаан төлөгдөх орлогыг үр дүнгийн тайланд орлогоор бүртгэсэн	1	1,781.9	0	-	1	1,781.9	1	1,781.9	0	-		
Мөнгөн хөрөнгийн данс хооронд шилжүүлсэн 6.8 сая төгрөгийн ажил гүйлгээг үр дүнгийн тайланд орлого, зардлаар бүртгэсэн	1	6,831.5	0	-	1	6,831.5	1	6,831.5	0	-		
Дүн	5	30,430.3	-	-	5	30,430.3	5	30,430.3	-	-		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Эд хариуцагчийн гаргасан тайланг нягтлан бодогч сар бүр хянаж шалгаагүй байна.	1						1						
Анхан шатны баримтын тулгалтаар 13 харилцагчдаас 86.1 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт аваагүй байна.	1						1						
Малын хөлийн татварын тайлан гаргаагүй, татвар төлөөгүй байна.	1						1						
Тайлант хугацаанд 2022 оны ажлын үр дүнг үнэлж, сумын Засаг даргын захирамжийг үндэслэн байгууллагын удирдах албан тушаалтанд 12 дугаар сард 41 хувиар буюу 0.5 сая төгрөгийг тооцож олгосон байна.	1	495.5	1	495.5									
Дүн	4	495.5	1	495.5			3						-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Тус байгууллагын Шилэн дансны цахим системд 7 хоногийн хугацаанд оруулбал зохих 1,131.2 сая төгрөгийн мэдээллүүдээс нийт 999.3 сая төгрөгийн 37 гүйлгээг хугацаа хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 13.6 сая төгрөгийн орлогын 2 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 19.6 сая төгрөгийн 7 шийдвэрийг огт мэдээлээгүй байна.	1						1	-
Дүн	1						1	-

